



АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ГАДААД ХУДАЛДААНЫ СТАТИСТИК 2025 I-X

2025 оны 11 сарын 10 өдөр

ГАРЧИГ

1. АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ.....	1
1.1. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төсөөлөл, гүйцэтгэл	1
3. ГАДААД ХУДАЛДАА.....	1
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	1
3.1.1. Уул уурхай, олборлох салбар	2
3.1.2. Газрын тосны салбар	3
3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар	3
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт	3
3.2.1. Газрын тосны салбар	4

1. АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

1.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨСӨӨЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025		Гүйцэтгэл хувь
			Төлөвлөгөө (Тод)	I-X	
1	Нүүрс	мян.тн	85,000.0	69,734.3	82.0%
2	Зэсийн баяжмал	мян.тн	2,010.0	1,855.8	92.3%
3	Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн	8,110.0	7,218.5	89.0%
4	Алт (Монголбанканд тушаасан) ¹	тн	17.0	12.7	74.5%
5	Газрын тос	мян.бар	4,248.9	2,959.8	69.7%
6	Цайрын баяжмал ²	мян.тн	150.0	126.0	84.0%
7	Хайлуур жоншны хүдэр, баяжмал ³	мян.тн	800.0	1,389.1	173.6%

Эх сурвалж: СЯ, ГЕГ, МБ

3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 21,596.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1,190.6 (5.2%) сая ам.доллаароор буурсан байна. Экспорт импортоос 2,864.9 сая ам.доллаароор өссөн үзүүлэлттэй гарсан байна.

3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Нийт экспорт 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 12,230.6 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 976.6 (7.4%) сая ам.доллаароор буурсан байна.

Үүнээс: Эрдэс бүтээгдэхүүний экспорт 11,482.7 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 877.1 (7.1%) сая ам.доллаароор буурсан байна.

¹ Монголбанкны үнэт металл худалдан авалтын мэдээлэл болно.

² Цайр нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно

³ Хайлуур жонш нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мөнгө, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 93.9 хувийг эзэлж байна.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

Барааны нэр	Хэмжих нэгж	2024	2025	Өөрчлөлт	
		I-X		+/-	%
Чулуун нүүрс	тн/ам.дол	110.9	66.7	-44.2	-39.9%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,926.9	2,441.4	514.5	26.7%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	81.1	72.0	-9.1	-11.2%
Цайрын баяжмал	тн/ам.дол	1,446.8	1,557.9	111.1	7.7%
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	236.9	182.3	-54.6	-23.1%
Молибдены баяжмал	тн/ам.дол	15,794.9	16,526.4	731.5	4.6%
Алт	кг/ам.дол	76,258.0	108,649.8	32,391.8	42.5%

Эх сурвалж: ГЕГ

Тайлбар: 1 - дахин их

3.1.1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

Нүүрсний экспорт: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 4,487.2 сая ам.долларын 69,734.3 мян.тн нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 2,921.4 (39.4%) сая ам.доллар буурсан ч, биет хэмжээгээр 1,240.9 (1.8%) мян.тн-оор өссөн байна. Нүүрсийг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

Зэсийн баяжмалын экспорт: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 4,530.6 сая ам.долларын 1,855.8 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 1,914.1 (73.2%) сая ам.доллар, биет хэмжээгээр 497.8 (36.7%) мян.тн-оор тус тус өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

Төмрийн хүдэр, баяжмалын экспорт: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 520.0 сая ам.долларын 7,218.5 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 25.5 (5.2%) сая ам.доллар, биет хэмжээгээр 1,124.9 (18.5%) мян.тн-оор тус тус өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 253.2 сая ам.долларын 1,389.1 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 3.0 (1.2%) сая ам.доллар, биет хэмжээгээр 333.1 (31.5%) мян.тн-оор тус тус өссөн байна. Хайлуур жоншны хүдэр, баяжмалын 88.8 хувийг Хятад, 10.8 хувийг Орос руу тус тус экспортолсон байна.



Цайрын баяжмалын экспорт: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 196.3 сая ам.долларын 126.0 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 40.2 (25.7%) сая ам.доллар, биет хэмжээгээр 18.1 (16.8%) мян.тн-оор тус тус өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

Молибдены баяжмалын экспорт: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 77.5 сая ам.долларын 4,690.0 тн молибдены баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 1.1 (1.5%) сая ам.доллароор өсч, биет хэмжээгээр 146.3 (3.0%) тн-оор буурсан байна. Молибдены баяжмалын 87.6 хувийг Хятад, 12.4 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

Алтны экспорт: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 919.2 сая ам.долларын 8,460.4 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 126.1 (15.9%) сая ам.доллароор өсч, биет хэмжээгээр 1,940.5 (18.7%) кг-аар буурсан байна. Алтны 86.5 хувийг Швейцар, 9.7 хувийг Америк руу тус тус экспортолсон байна.

3.1.2. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Газрын тосны экспорт: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 217.7 сая ам.долларын 2,959.8 мян.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 55.4 (20.3%) сая ам.доллар, биет хэмжээгээр 458.4 (13.4%) мян.бар-иар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь Хятад руу экспортолсон байна.

3.1.3. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Катодын зэс: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 117.4 сая ам.долларын 12,751.3 тн катодын зэс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 26.9 (29.7%) сая ам.доллар, биет хэмжээгээр 2,518.7 (24.6%) тн-оор тус тус өссөн байна.

3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Нийт импорт 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 9,365.7 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 214.1 (2.2%) сая ам.доллароор буурсан байна.

Үүнээс, Эрдэс бүтээгдэхүүний импорт 1,946.6 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 73.0 (3.6%) сая ам.доллароор буурсан байна.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

Барааны нэр	Хэмжих нэгж	2024	2025	Өөрчлөлт	
		I-X		+/-	%
Автобензин	тн/ам.дол	716.7	711.2	-5.5	-0.8%
Дизель түлш	тн/ам.дол	795.5	711.6	-83.9	-10.5%

Эх сурвалж: ГЕГ

Тайлбар: 1 - дахин их

3.2.1. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 86.9 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.

2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1,691.9 сая ам.долларын 2,294.7 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 88.4 (5.0%) сая ам.доллаароор буурч, биет хэмжээгээр 70.8 (3.2%) мян.тн-оор өссөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 91.3 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 28.5 хувийг автобензин, 62.8 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

Автобензины импорт: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 482.5 сая ам.долларын 678.5 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 26.2 (5.2%) сая ам.доллар, биет хэмжээгээр 31.4 (4.4%) мян.тн-оор тус тус буурсан байна.

Дизель түлшний импорт: 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1,061.7 сая ам.долларын 1,492.0 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 19.1 (1.8%) сая ам.доллаароор буурч, биет хэмжээгээр 133.4 (9.8%) мян.тн-оор өссөн байна.

--- оОо ---